

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС

МЭДЭЭ

Өргөдөл шийдвэрлэлтийг зохион байгуулсан ажлын тухай

2019 оны 12 дугаар сарын 27

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамж, холбогдох бусад эрх зүйн актын хүрээнд 2019 онд ажилтан, албан хаагчдаас ирсэн өргөдлийн шийдвэрлэлтийг зохион байгуулж ажиллалаа.

Нэг. Өргөдлийн бүртгэл, шийдвэрлэлтийн мэдээ

Манай байгууллага нь Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/1086 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-д нийцүүлэн ажилтан, албан хаагчид, иргэдээс ирсэн өргөдлийг тухай бүр бүртгэлийн системд байршуулан, шийдвэрлэлтийн явцыг ил тод, шуурхай байлгах зорилгоор явцын тэмдэглэлийг хуанлийн 10 хоног тутам хөтлөн ажиллаж байна.

Иргэд, аж ахуйн нэгжүүд болон ажилтан, албан хаагчдаас тайлант хугацаанд нийт 215 өргөдөл ирсэнээс бүх өргөдлийг бүрэн шийдвэрлэж хариуг өгсөн.

Ажилтан, албан хаагчдаас хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар ирсэн өргөдлийг холбогдох ажилтан бүртгэж удирдлагад шилжүүлэн, удирдлагаас тухайн харилцааг зохицуулах чиг үүрэг бүхий албан хаагчид шийдвэрлэх чиглэл өгч шилжүүлснээр 2 удаагийн шат дамжлагатайгаар шийдвэрлэж байна.

Хоёр. Өргөдөлийн хандалтын мэдээ

Байгууллагад ирсэн өргөдлийг хандалтын төрлөөр нь ангилвал:

- Хөдөлмөрийн хөлстэй холбоотой өргөдөл – 59;
- Захиргааны чөлөө хүссэн өргөдөл – 52;
- Ажилд орох, чөлөөлөгдөхтэй холбоотой өргөдөл – 48;
- Жирэмсний болон ээлжийн амралт хүссэн өргөдөл – 24;
- Нийгмийн асуудал шийдвэрлүүлэх тухай өргөдөл – 26;
- Ажилд шилжих, дэвшин ажиллах тухай өргөдөл - 2;
- Бусад асуудлаар - 4.

Өргөдлийн төрлийг нийт өргөдөлд эзэлж буй хувиар нь харьцуулвал:




График 1: Өргөдлийг хандалтын төрлөөр нь ангилвал.

Мөн тайлант хугацаанд ирсэн 215 өргөдлийн хариуг epg.ulaanbaatar.mn цахим хуудсанд байршуулахын зэрэгцээ тухайн албан хаагчид утсаар мэдэгдэж, асуудлыг газрын даргын тушаалаар шийдвэрлэсэн тохиолдолд тухайн тушаалыг ажилтанд танилцуулж буй болно.

Гурав. Өргөдлийн шийдвэрлэлтийг өмнөх үетэй харьцуулсан байдал

Тайлант хугацаанд өргөдөл гомдлыг хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн зөрчилгүй, өдөрт нь багтаан хүлээн аваагүй 1 зөрчил, явцын тэмдэглэл хөтлөөгүй 3 зөрчил бүртгэгдсэн.




График 2. Өргөдөл шийдвэрлэлтийг өмнөх онтой харьцуулсан байдал

Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа 2018 оны эхний хагас жилд 5 хоног 5 цаг 47 минут, сүүлийн хагас жилд 4 хоног 11 цаг 25 минут байсан бол энэ оны эхний хагас жилийн байдлаар 3 хоног 19 цаг 21 минут, сүүлийн хагас жилд 3 хоног 17 цаг 13 минут болж, өмнөх оны мөн үеэс 18 цаг 12 минутаар, 2019 оны эхний хагас жилийн дундаж хугацаанаас 2 цаг 7 минутаар тус тус тогтмол буурсан үзүүлэлттэй байна.




График 3. Өргөдөл шийдвэрлэлтийн дундаж хугацаа

ДҮГНЭЛТ

Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн хавсралтын дагуу өргөдөл шийдвэрлэлтийг зохион байгуулсан ажлын тайланг улирал бүрийн сүүлийн сарын 30-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.


Тус газар нь төрийн албан хаагчийн ажиллах ая тухтай орчин нөхцөлийг бүрдүүлэх үндсэн чиг үүрэгтэй байгууллага учир дотогш чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Энэ үүднээс иргэдийн эрх ашгийг хөндсөн шийдвэр гаргадаггүй ба байгууллагын ажилтан, албан хаагчдаас хөдөлмөрийн харилцаатай холбоотой асуудлаар өргөдөл ихэвчлэн ирдэг болно. Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас 214 өргөдөл, төрийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой иргэнээс 1 санал ирсэнийг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем egr.uulaanbaatar.mn цахим хуудсаар бүртгэж, бүрэн шийдвэрлэсэн байна.

Энэ онд нийт 214 өргөдөл бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 8,54%-иар буурсан, зөрчлийн тоо 2018 онд 62 байсан ба 2019 онд 4 болж 93,54%-иар, шийдвэрлэлтийн дундаж хугацаа өмнөх онд 6445 минут байсан нь энэ онд 5184 минут болж 19.5%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

 Т.ИТГЭЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ
ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ
ХАРИУЦСАН АЖИЛТАН

 Э.ХОРОЛДУЛАМ